



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Хэвлэлийн мэдээ:
31.10.2019

Холбоо барих:
+976 9511 7771

АмЧам Монгол нь АНУ-ын бизнесийн төлөөлөгчдийн айлчлалыг амжилттай зохион байгууллаа

УЛААНБААТАР, Монгол улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь 2019 оны 10-р сарын 28-30-ны өдрүүдэд 2 дахь жилдээ АНУ-ын Худалдааны Яамнаас итгэмжлэгдсэн Америкийн томоохон компаниудын бизнес айлчлалыг АНУ-ын ЭСЯ-тай хамтран амжилттай зохион байгууллаа. Энэхүү бизнес айлчлал нь Америкийн компаниудад Монгол Улсад бизнес эрхлэх боломж, тулгарах бэрхшээлүүдийг тодорхойлж хамтран ажиллах сонирхолтой компаниуд болон төр, засгийн холбогдох удирдлагуудтай уулзах боломжийг олгодог билээ. Түүнчлэн энэхүү айлчлал нь Америкийн компаниудад бизнесээ тэлэх, ирээдүйн хамтрагчаа олж авах боломж олгосон үр дүнтэй арга хэмжээ юм.

Энэ жил АмЧам Монгол нь Америкийн нэр хүндтэй Boeing, Dow Chemicals, Monsoon Blockchain Storage, Wabtec, Caterpillar-ийн албан ёсны дистрибьютор Вагнер Ази зэрэг таван компанийн есөн төлөөлөгчийг хүлээн авлаа – компаниуд оролцлоо. Эдгээр компаниуд нь уул уурхай, хүнд үйлдвэр, зам тээвэр, хөдөлгүүр, агаарын тээвэр, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон блокчейн технологийн компаниуд юм. Айлчлалын хүрээнд зочид төр засгийн өндөр албан тушаалтнууд, бодлого боловсруулагчидтай уулзаж Монгол улсын хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн орчин, эдийн засгийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан юм. Айлчлалын эхний өдөр АНУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд Майкл Клечески төлөөлөгчдийг хүлээн авч, үргэлжлүүлээд Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С. Батболд, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нартай уулзаж мөн Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн нар бизнес айлчлалын төлөөлөгчдийг хүлээн авлаа.

Айлчлалын хоёр дахь өдөр төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулгад бараалхаж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З. Энхболдтой уулзсан юм. Уулзалтын үеэр АНУ-ын Худалдааны яамны Хятад, Монголыг хариуцсан дэд сайдын орлогч Алан Төрли, "Монгол Улсад хийж буй энэхүү бизнес айлчлал нь Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп нарын хэлэлцээрийн үеэр хоёр орны эдийн засаг, худалдааны харилцааг өргөжүүлэх шаардлагатай байгаа тухай ярилцсаныг ажил хэрэг болгох зорилготой юм" хэмээн онцоллоо. Үргэлжлүүлэн, "АмЧам Монгол бол АНУ болон Монгол улсын бизнесийг холбох гүүр болж өгдөг чухал үүрэгтэй байгуулага юм" гэв.

Мөн Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөлөгчидтэй уулзаж Экспорт Монгол Үзэсгэлэнд оролцож, Монголын бараа бүтээгдэхүүнийг экспортлоход анхаарах асуудлуудын талаар зөвлөгөө өгч санал солилцов.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.